

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

2015 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

475/182
Дугаар 324

Улаанбаатар хот

“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж,
зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5, 35.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

3.5. “Зээлдүүлэгч активыг холбогдох сангаас зөвхөн дор дурдсан нөхцөлд дараах баримт бичгийг үндэслэн хорогдуулж болно:” гэснийг “Зээлдүүлэгч активыг холбогдох сангаас дор дурдсан нөхцөлд дараах баримт бичгийг үндэслэн хагас жил тутам хорогдуулна:” гэж;

3.5.4. “Төлбөр хариуцагчийн талаар шүүхэд хандсан боловч тодорхой шийдвэр гаргах боломжгүй нөхцөл бий болсон активыг муу ангилалд орсноос хойш хагас жилийн дараа өөрийн хөрөнгийн 1 хувь хүрэхгүй дүнтэй активыг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр, өөрийн хөрөнгийн 1 хувиас доошгүй дүнтэй активыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр.” гэснийг “Зээлдүүлэгчийн үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж тооцогдсон муу активыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр.” гэж.

2.Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д дараах заалтыг доор дурдсанаар нэмж оруулсугай.

3.5.5. “Банкны хувь нийлүүлэгч, эрх бүхий албан тушаалтанд энэ журмын 3.5.1, 3.5.4 дэх заалт хамаарахгүй.”;

3.11. “Зээлдүүлэгч энэ журмын 3.5-д заасны дагуу активыг холбогдох сангаас хаасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийн хамт жил бүрийн 4 дүгээр сард багтаан Монголбанкинд хүргүүлнэ.”;

3.12. “Зээлдүүлэгч нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд ирүүлэх зээлдэгчийн талаарх мэдээлэлдээ тухайн активыг холбогдох сангаас хаасан талаарх мэдээллийг энэ журмын 3.5-д заасан давтамжийн дагуу үнэн зөв тусгасан байна.”

3.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг банкуудын Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Д.Ганбат), Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар (Б.Нямаа)-т тус тус үүрэг болгосугай.

